



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

2.1. Бодлого, төлөвлөлтийн газар (судалгаа, шинжилгээний хэлтэстэй);

2.2. Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (цахим засаглалын хэлтэс, нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтэстэй);

2.3. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (сансрын холбооны хэлтэс, шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэстэй);

2.4. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

2.5. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);

2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны орон тооны дээд хязгаарыг 87 байхаар тогтоосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ц.НЯМДОРЖ



Засгийн газрын 2022 оны 13 дугаар
тогтоолын хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Цахим хөгжил, харилцаа холбооны яам (цаашид “яам” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Монгол Улсын Засгийн газар (цаашид “Засгийн газар” гэх), Цахим хөгжил, харилцаа холбооны сайд (цаашид “сайд” гэх)-ын эрхлэх асуудлын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологи, радио давтамж, сансар, өргөн нэвтрүүлэг, шуудан, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, кибер аюулгүй байдал, цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого, зохицуулалт, салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвор суурьшилтай ажиллуулах, салбарын инновацийг хөгжүүлэх талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төслийг боловсруулах, харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын стратеги, бодлого, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2.Үндэслэл

Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэтгэлийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3.Хууль, эрх зүйн орчин

1.3.1.Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Шуудангийн тухай хууль;
- Радио долгионы тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Бусад холбогдох хууль тогтоомж.

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэтгэлийн талаар баримтлах бодлого”-ыг баримтлан хуульд заасан Сайдын эрхлэх